

2023-2 семестрийн гадаад шинэ-шилжин орох тусгай сонгон шалгаруулалтын ярилцлага явагдах аргын танилцуулага

1. Ярилцлагын арга : Онлайн видео ярилцлага(ZOOM),


1(ярилцлага өгөгч) : 2(ярилцлага авагч) хэв маяг

2. Ярилцлагын огноо : 2023. 06. 10.(Бямба), 06. 11.(Ням), 06. 17.(Бямба)

3. Ярилцлагын цаг : 10:00~12:00, 13:30~15:30, 16:00~18:00 / 1 хҮн 6 минут Үргэлжлэнэ

※ Ярилцлага өгөгч бүрд нарийн ярилцлагын огноо болон цаг, нэвтрэн орох URL - г дараа нь хувийн E-MAIL - рҮҮ мэдэгдэх бөгөөд, заавал заасан цагт нэвтрэн орох шаардлагатай

4. Ярилцлагын эрэмбэ дараалал



※ Тогтоосон ярилцлагын цагаас 20 минутын өмнө хҮлээлгийн өрөөнд орж ирсэн байх

5. Ярилцлагын дараалал

- 1) ХҮлээж буй оюутныг шалгалтын дугаарын дарааллын дагуу нэг удаа 1 хҮн ярилцлага өгөх болно
- 2) Ярилцлагын дараалал нь нөхцөл байдлаас хамааран хэсэг нь өөрчлөгдөж болно

6. Анхаарах зүйл болон мэдэгдэл

1) ZOOM ажиллуулахтай холбоотой

- (1) Дүрсээ харсан ярилцлага нь камер, микрофон, спикер холбосон PC эсвэл ухаалаг утас(камер, микрофон, спикер ашиглах боломжтой байх бөгөөд, ZOOM суулгах боломжтой төхөөрөмж)-тай байж оролцох боломжтой юм.
※ Болж өгвөл PC ашиглан нэвтрэхийг хҮсэх бөгөөд, PC ашиглах боломжгүй тохиолдолд л ухаалаг утас хэрэглэхийг ХҮсье. Ухаалаг утасны хувьд зарим Үйлдэл нь хангагдаагүйн улмаас ярилцлага саадгүй явагдахгүй байж болох бөгөөд, Үүнээс Үүдэн хохирол учирвал шалгалт өгөгч бүх хариуцлыг ХҮлээх болно гэдгийг мэдэгдэж байна.
- (2) PC болон ухаалаг утасны ZOOM ажиллуулах боломжтой эсэх болон хувийн камер, микрофон, спикер зэргийг ашиглах боломжтой эсэхийг урьдчилан шалган, дууны чанга сул болон дүрсний тестийг мөн хийхийг ХҮсье.
※ Микрофон болон спикэрийн нөхцөл байдлаас хамааран ярилцлага явуулах бэрхшээлтэй болж магадгүй бөгөөд аль болох чихэвч(Микрофон болох чихэвч) ашиглахыг ХҮсье.
- (3) Баригдсан зай хэрэглэдэг тоног төхөөрөмжөөр нэвтрэн орж байгаа тохиолдолд, зайгаа цэнэгтэй байгаа эсэх болон интернет холболт асуудалгүй байгаа эсэхийг шалгана уу.
- (4) Дүрсээ харсан ярилцлагын хувь хҮний дуу хураах, бичлэг хийхийг хориглох бөгөөд, баригдсан тохиолдолд хууран мэхэлсэн гэж Үзнэ.
- (5) Нарийн ZOOM - д нэвтрэх болон ашиглах аргыг тусдаа 'ZOOM ашиглах зааврын хөтөч' - г шалгахыг ХҮсье.
- (6) Ярилцлагын өдөр ZOOM нэвтрэн орох Үед асуудал Үүссэн тохиолдолд Олон Улсын Боловсрол Солилцооны Төв (холбоо барих утас : 041-530-1304) рҮҮ холбоо барина уу.

2) Ярилцлагын орчин болон цагтай холбоотой

- (1) Ярилцлагын байршил нь тусгаарлагдсан орчин, интернет холболт болон хурдны асуудалгүй газар байх бөгөөд, ярилцлагын орчинд заавал ганцаараа байх.
※ Ярилцлагын орчинд өөр ХҮн байгаа тохиолдолд шударга бус Үйлдэлд тооцогдож болно.
- (2) Тогтоосон цагаас гадуур ярилцлагад оролцох боломжгүй юм.
※ Тогтоосон цагаас өмнө нэвтэрсэн тохиолдолд ХҮчээр гаргах бөгөөд, заасан цагаас хойш нэвтэрсэн тохиолдолд байхгүйгээр тооцох болно.
- (3) Тогтоосон ярилцлагын цагийг өөрчлөх боломжгүй.

3) Бусад

- (1) Даруу төлөв хувцаслан ярилцлагад оролцохыг ХҮсье.
- (2) Биеийн байцаалт шалгахад гадаад иргэний Үнэмлэх, БНСУ - н жолооны Үнэмлэх, гадаад паспорт, оюутны Үнэмлэх(манай сургуулийн солилцоо болон хэлний бэлтгэлийн оюутны оюутны Үнэмлэх) ХҮлээн зөвшөөрөгдөх тул, ярилцлагын өмнө урьдчилан бэлдэхийг ХҮсье.
- (3) Дүрсээ харсан ярилцлагатай холбоотой бусад лавлах зүйл байвал Олон Улсын Боловсрол Солилцооны төв (холбоо барих утас : 041-530-1304) - тэй холбогдоно уу.